

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/42

Арвайхээр сум

Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын  
тусгай зөвшөөрөл сунгах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2,19.3.19.18, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 5.5.1, Эрүүл мэндийн сайдын 2023 ны А/383 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын ажиллах журам”- ын 4.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой ажлыг гүйцэтгэх ажлын албаны ирүүлсэн санал, дүгнэлт, Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны 12 дугаар сарын 22 -ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я. Жаргалд) -д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 12 дугаар сарын 25-ны  
өдрийн 41 дугаар тушаалын  
хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ, НЭР БҮХИЙ  
АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа
1	"Нарны дөш" ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ	Өвөрхангай, Арвайхээр сумын 5-р баг	Сунгах	5 жил

---oOo---